



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/151

Хажуу шинэ-Ус

Эзэмшил газрын хэмжээг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5 дугаар зүйлийн 5.1.3.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Угтаал сумын 4 дүгээр багийн нутаг дэвсгэрт Засаг даргын тамгын газар (9033572)-ийн Цэнгэлдэх хүрээлэн наадмын талбайн зориулалттай 2247 м.кв (0,2247 га) эзэмшил газрын хэмжээг 12628 м.кв (1,26 га) болгон хэмжээг өөрчилж зориулалтаар нь 9 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Эзэмшил газрын хил заагийг тогтоон газрыг хүлээлгэн өгч, гэрээ байгуулан гэрчилгээ олгож, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Н.Лхагва-Учрал)-д даалгасугай. Газрыг зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр эзэмшиж гэрээнд заасан үүргээ биелүүлж байхыг Говь-Угтаал сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Өлзийтогтох)-т үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулж Сумын Засаг даргын 2018 оны А/35 дугаар захирамж мөн газар эзэмших 0000098504 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Т.АРИУНАА